



I-II/2021


Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 13



Төлбөрийн тэнцэл 2021 оны 2 дугаар сард 167.7 сая америк долларын ашигтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 59.4 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 306.0 (83.7%) сая америк доллароор буурчээ. Тус бууралтад барааны худалдаа өмнөх оны мөн үеэс 368.4 сая америк доллароор өсөж, 272.5 сая америк долларын ашигтай гарсан нь голлон нөлөөлсөн байна. Харин урсгал дансны алдагдал 2021 оны 2 дугаар сард 28.8 сая америк доллар болж, өмнөх сараас 1.8 сая америк доллароор буурчээ.

Зураг 1. Урсгал данс, сая америк доллароор, сараар



Үйлчилгээний худалдааны орлого 2021 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 110.6 сая америк доллар, зарлага 295.5 сая америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 20.8 сая америк доллароор, зарлага 61.7 сая америк доллароор тус тус буурсан байна.

Хүснэгт 1. Үйлчилгээний худалдааны тэнцэл, салбараар

Үзүүлэлт	2020*		2021*		Хөрөнгийн данс 2021 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 16.2 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.3 сая америк доллароор өссөн байна. Харин хөрөнгийн дансны ашиг 2021 оны 2 дугаар сард 7.6 сая америк доллар болж, өмнөх сараас 0.9 сая америк доллароор буурчээ.
	II	I-II	II	I-II	
	сая америк доллар				
Үйлчилгээ	- 116.7	- 225.9	- 91.7	- 185.0	
Кредит	44.1	131.3	72.5	110.6	
Дебит	160.7	357.3	164.2	295.5	
Тээвэр	- 4.8	- 16.2	12.1	0.5	
Кредит	24.0	77.5	47.5	74.7	
Дебит	28.8	93.7	35.4	74.2	
Аялал	- 79.3	- 145.1	- 84.6	- 131.8	
Кредит	5.8	19.2	1.0	1.8	
Дебит	85.1	164.3	85.6	133.5	
Бусад үйлчилгээ	- 32.5	- 64.7	- 19.2	- 53.7	
Кредит	14.3	34.6	24.0	34.1	
Дебит	46.8	99.3	43.2	87.8	

Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 239.7 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 38.6 сая америк доллароор буурчээ. Харин өмнөх сараас 259.4 сая америк доллароор өссөн байна. Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс буурахад, бусад хөрөнгө оруулалт 81.0 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2. Төлбөрийн тэнцлийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2020*		2021*		Төлбөрийн тэнцэл 2020 оны эхний 2 сард 82.8 сая америк долларын алдагдалтай байсан бол 2021 оны эхний 2 сарын урьдчилсан гүйцэтгэлээр алдагдал өмнөх оны мөн үеэс 89.8 сая америк доллароор буурч, 7 сая америк долларын ашигтай байна. Мөн төлбөрийн тэнцлийн ашиг 2021 оны 2 дугаар сард 167.7 сая америк доллар болж, өмнөх сараас 328.4 сая америк доллароор өсжээ.
	II	I-II	II	I-II	
	сая америк доллар				
Урсгал данс	- 133.4	- 365.4	- 28.8	- 59.4	
Хөрөнгийн данс	5.7	10.9	7.6	16.2	
Санхүүгийн данс	- 178.9	- 278.3	- 249.5	- 239.7	
Алдаа болон орхигдуулга	- 43.2	- 6.6	- 60.7	- 189.5	
Нөөц хөрөнгө	7.9	- 82.8	167.7	7.0	

Ойлголт, тодорхойлолт:

Төлбөрийн тэнцэл: Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

Урсгал данс: Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс: Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс: Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед “+” буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед “-” буюу ашигтайг илэрхийлнэ.

Цэвэр нөөц: Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

Шууд хөрөнгө оруулалт: Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.

Эх үүсвэр: Монголбанк

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 15



*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414*

*Эдийн засгийн статистикийн албаны
статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-261563*

